



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ДЭЛГЭРХААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 10 сарын 08 өдөр

Дугаар 8/101

Дэлгэрхаан сум

Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаах иргэдийг
ажилд татан оролцуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Батлах хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4, 17.1.6, Цэргийн албаны тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.7 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2024-2025 оны өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд 50 тн өвсийг Баянхутаг сумаас ачих, сумын нөөцийн агуулахад буулгах ажилд цэргийн албыг биеэр дүйцүүлэн хааж байгаа тус сумын иргэдийг татан оролцуулсугай.

2.Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хааж байгаа тус сумын иргэн Э.Лувсандамбийжамцан, С.Баттэмүүлэн, Э.Энхсайхан, Д.Амарсанаа Б.Бат-Эрдэнэ нарыг 2024 оны 10 дугаар сарын 09-нөөс 10 дугаар сарын 15-ыг дуустал хугацаанд хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг хангаж ажиллуулсугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, холбогдох тайланг Хэнтий аймгийн цэргийн штабт хүргэж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын (Д.Урангоо)-д үүрэг болгосугай.

ДАРГА

Э.ТӨГӨЛДӨР

